



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ*

2020 оны 1 дүгээр сар


Ерөнхий тойм: Энэ оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 16%-иар буюу 179 сая ам.доллараар буурч 932 сая ам.доллар байв. Үүнд экспорт 24%-иар буюу 148 сая ам.доллараар, импорт 6%-иар буюу 31 сая ам.доллараар тус тус буурсан нь нөлөөлөв. Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 118 сая ам.доллараар буурч 14 сая ам.долларын алдагдалтай гарлаа.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 1 сар			Өөрчлөлт			
	2017	2018	2019	2018/2017		2019/2018		2018	2019	2020	2019/2018		2020/2019	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	10,536	12,887	13,747	2,351	22%	860	7%	785	1,111	932	326	42%	(179)	-16%
Экспорт	6,201	7,012	7,620	811	13%	608	9%	424	607	459	183	43%	(148)	-24%
Импорт	4,335	5,875	6,127	1,540	36%	252	4%	361	504	473	143	40%	(31)	-6%
Тэнцэл	1,865	1,137	1,492	(728)		356	31%	63	103	(14)	41	65%	(118)	-114%

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл** 2020 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 84 сая ам.доллараар буурч 40 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Зураг 1. Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /3 сарын гулсах дундаж/




Зураг 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 60% буюу 560 сая ам.долларын худалдааг БНХАУ-тай, 21% буюу 194 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. ОХУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 33%-иар өссөн бол БНХАУ-тай хийсэн худалдаа 9%-иар буурлаа.

Зураг 3. Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



Гадаад худалдааны нөхцөлийн индекс 2020 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 10%-иар, өмнөх сараас 20%-иар өсч 1.920-д хүрлээ. Худалдааны нөхцөлийн индекс өмнөх сараас сайжрахад чулуун нүүрсний хилийн үнэ өссөн болон хөрөнгө оруулалтын барааны үнийн бууралтаар тайлбарлагдаж байна.

*Энэхүү тоймыг ГЕГ-ын "Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл"-д үндэслэн, дэлхийн улс орнуудын Төв банкны практикт нийцүүлж, судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээнд зориулан боловсруулав.

** Нийт худалдааны дүнгээс дахин экспорт/импорт, боловсруулах бараа, бараа солилцоо, хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа, гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа болон бусад барааг хассан дүн болно.

Импорт 2020 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 6%-иар буюу 31 сая ам.доллараар буурав. Импортын 6 нэгж хувийн бууралтийг ерөнхий ангиллаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт 5 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүний бууралт 4 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний өсөлт 3 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна.

Хүснэгт 4. Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2018			2019			2020			Δ (2019/2018)			Δ (2020/2019)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	%²	Дүн	Өсөлт	%²
Хэрэглээний бүтээгдэхүүн		111	31%		139	28%		120	25%	28	25%	8%	(20)	-14%	-4%
Түргэн эдэлгээтэй	68	59	16%	80	63	13%	82	65	14%	5	8%	1%	2	4%	0%
Хүнс	33	41	11%	34	44	9%	35	46	10%	3	7%	1%	2	4%	0%
Эм, тариа	0	7	2%	0	6	1%	0	7	2%	(1)	-12%	0%	1	12%	0%
Бусад турган эдэлгээтэй бараа	35	10	3%	45	13	3%	48	13	3%	3	25%	1%	(0)	-1%	0%
Удаан эдэлгээтэй	14	53	15%	21	76	15%	11	54	11%	24	45%	7%	(22)	-29%	-4%
Гутал, хувцас, цүнх	5	5	1%	7	5	1%	3	4	1%	0	4%	0%	(1)	-25%	0%
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба тавилга	4	10	3%	6	11	2%	2	9	2%	1	7%	0%	(2)	-19%	0%
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	0	32	9%	0	54	11%	0	35	7%	22	70%	6%	(19)	-35%	-4%
Бусад удаан эдэлгээтэй бараа	4	6	2%	7	6	1%	6	6	1%	1	10%	0%	(0)	0%	0%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	110	122	34%	108	207	41%	118	182	39%	85	70%	24%	(25)	-12%	-5%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	1	81	22%	2	158	31%	2	137	29%	77	95%	21%	(20)	-13%	-4%
Судлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	0	16	4%	1	63	13%	1	51	11%	48	309%	13%	(13)	-20%	-3%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	1	66	18%	2	94	19%	2	87	18%	29	44%	8%	(7)	-8%	-1%
Барилгын материал	22	25	7%	37	36	7%	37	30	6%	10	42%	3%	(5)	-15%	-1%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	3	16	4%	2	14	3%	2	15	3%	(2)	-11%	0%	1	7%	0%
Аж үйлдвэрлэлийн орц	114	52	15%	176	50	10%	189	49	10%	(2)	-4%	-1%	(1)	-2%	0%
Хүнсний орц	29	7	2%	3	1	0%	6	2	0%	(5)	-79%	-1%	1	41%	0%
Химийн бүтээгдэхүүн	16	8	2%	15	8	2%	12	7	1%	0	1%	0%	(1)	-17%	0%
Даавуу, утас, арьс, савхин эдлэл	4	2	1%	6	3	1%	9	2	0%	1	41%	0%	(1)	-27%	0%
Цахилгаан эрчим хүч	0	12	3%	0	10	2%	0	13	3%	(2)	-19%	-1%	3	29%	1%
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	0	0	0%	0	0	0%	0	0	0%	0	156%	0%	0	32%	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтай	61	23	6%	84	28	6%	91	26	5%	5	20%	1%	(2)	-8%	0%
Нефтийн бүтээгдэхүүн	114	75	21%	176	106	21%	189	122	26%	31	42%	9%	15	14%	3%
Дизель түлш	81	51	14%	106	66	13%	111	71	15%	15	30%	4%	5	7%	1%
АИ-92, АИ-95	24	16	4%	51	28	6%	50	32	7%	13	79%	3%	4	13%	1%
А-80 болон бусад	9	8	2%	18	12	2%	27	19	4%	4	46%	1%	7	55%	1%
Бусад	2	1	0%	1	1	0%	20	0	0%	(0)	-7%	0%	(0)	-39%	0%
Нийт дүн		361		504			473			143	40%		(31)	-6%	

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 5. Импортын өөрчлөлт, 2020 он эхний 1 сар

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	(33)	166%	13	-66%	(20)	-14%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	0	0%	(25)	100%	(25)	-12%
Аж үйлдвэрлэлийн орц	5		(6)		(1)	-2%
Нефтийн бүтээгдэхүүн	9	56%	7	44%	15	14%
Дизель түлш	3	66%	2	34%	5	7%
АИ-92, АИ-95	(1)	-19%	4	119%	4	13%
А-80 болон бусад	6	90%	1	10%	7	55%
Бусад	0		(1)		(0)	-39%
Нийт дүн	(19)	60%	(12)	40%	(31)	-6%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Зураг 5. Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/



2020 оны эхний 1 дүгээр сарын гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 25 сая ам.доллараар, хэрэглээний бүтээгдэхүүний импорт 20 сая ам.доллараар буурсан бол нефтийн бүтээгдэхүүний импорт 15 сая ам.доллараар өссөнөөр нийт импорт 31 сая ам.доллараар буурлаа.

Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2020 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 7 хувиар, өмнөх сараас 2 хувиар өсч тонн тутамд 645 ам.долларт хүрэв.